



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БУСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/42

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6.1, 9.4, 18.1.4, 18.2.3, 28.1.2 дугаар заалтуудыг үндэслэн тушаах нь:

1. Цахилгааны хэлбэлзэл үүссэн шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг тодорхойлох, хохирлын хэмжээг тодорхойлох, тухайн ажлын байруудад эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Баянмөнх (Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал)
Нарийн бичиг: Б.Эрдэнэзул (Хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны

эрсдэлийн менежер)

Гишүүд: Д.Наранхүү (Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

Г.Мөнхдавга (Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга)

Э.Түмэнжаргал (Эдийн засагч)

Б.Цэндоо (IT инженер)

Д.Баярсайхан (IT инженер)

Н.Бөхшандас (Цахилгаанчин)

Ц.Базархүү (Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер)

2. Ажлын хэсэг байгуулагдаж байгаатай холбоотой ажил үүргийн хуваарийг гарган танилцуулж, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг баталгаажуулж фото зураг авах, мэргэжлийн гэрээт байгууллагуудтай хамтран хохирлын хэмжээг тогтоон, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажиллуулсугай.

3. Ажлын хэсгийн ажил үүрэгт хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэл удирдлага дотоод хяналтын албаны дарга (Д.Аззаяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Г.ДАШЖАНЦАН